

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД,
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД,
САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2017 оны 12 дугаар
сарын 15-ний өдөр

Дугаар А/376; А/217 /366.....

Улаанбаатар
хот

Журамд өөрчлөлт оруулах
тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалт, Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2017-2018 оны Улсын нэмэлт хэлэлцээрийн 5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 2007 оны 307/91/237 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш, зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам"-ын 25 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/25 дахь заалт:

"25. Сурагчийн улирлын амралт болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл, сургалтын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоосон боловч багш үндсэн ажлаа гүйцэтгэж байгаа тохиолдолд багшид албан тушаалын үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, урамшил олгоно."

2. Тушаалын хэрэгжилтийг 2018 оны батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлэх арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллахыг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар, нийслэлийн Боловсролын газарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалыг 2018 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

